



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
 ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
 ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠲᠤᠨ
 ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
 ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
 ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/177

Алтай хот

Тусгай зөвшөөрөл сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.7 дахь хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээнд тавигдах шаардлагыг хангаж, спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаагаар худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахаар материалаа ирүүлсэн аж ахуйн нэгжийг хавсралтаар баталсугай.

2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хууль тогтоомж, шаардлага журмыг зөрчсөн тохиолдолд зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авч ажиллахыг Цагдаагийн газар (Н.Мэндбаяр), холбогдох сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дугаар сарын 17-ны өдрийн 1179 дугаар захирамжийн хавсралт

СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ СУНГАСАН АЖ АХУЙН НЭГЖҮҮД

Д/д	Сумын харьяалал	Аж ахуйн нэгжийн нэр	Дэлгүүр, үйлчилгээний газрын нэр	Байрлал	Худалдаа үйлчилгээний хэлбэр
1.	Баян-Уул сум	"Насан шанд" ХХК	8 нэрийн хүнсний дэлгүүр	Сумын төв	Худалдах
2.	Бугат сум	"Нарлаг сүж" хоршоо	Сангийн далай хүнсний дэлгүүр	Сумын төв	Худалдах
3.	Бугат сум	"Баян биж" ХХК	Гоомарал хүнсний дэлгүүр	Сумын төв	Худалдах
4.	Дарив сум	"Буян-Ундрал" хоршоо	Сутай худалдааны төв	Сумын төв	Худалдах
5.	Дарив сум	"Буян-Ундрал" хоршоо	Ундрал зоогийн газар	Сумын төв	Үйлчлэх
6.	Дэлгэр сум Гуулин тосгон	"Талын зээр" хоршоо	Өнөрмөнх хүнсний дэлгүүр	Тосгоны төв	Худалдах
7.	Тайшир сум	"Дагина хулан"	Баян-Өндөр хүнсний дэлгүүр	Сумын төв	Худалдах
8.	Цогт сум	"Тайж чоно" ХХК	Ажаагийн хүнсний дэлгүүр	Сумын төв	Худалдах
9.	Цээл сум	"Хөвчийн найтуур" ХХК	8 нэрийн хүнсний дэлгүүр	Сумын төв	Худалдах
10.	Есөнбулаг сум	"Ундаргын эх" ХХК	Баянхутаг хүнсний дэлгүүр	Жинст	Худалдах
11.	Есөнбулаг сум	"Гэрэлт есөн цалиг" ХХК	Өрнөн-Ундрах хүнсний дэлгүүр	Индэрт баг	Худалдах
12.	Есөнбулаг сум	"Гэрэлт есөн цалиг" ХХК	ВМ диско баар	Оргил баг	Үйлчлэх
13.	Есөнбулаг сум	"Баталгаат-Анд"	Дархан Алтай хүнсний дэлгүүр	Индэрт баг	Худалдах
14.	Есөнбулаг сум	"Их баян Мянган"	Баянгол хүнсний дэлгүүр	Оргил баг	Худалдах
15.	Есөнбулаг сум	"Түшигхайрхан" ХХК	Түшиг хүнсний дэлгүүр	Баянхайрхан баг	Худалдах
16.	Есөнбулаг сум	"Андис өв" ХХК	Өндөр ээж хүнсний дэлгүүр	Сумын төв	Худалдах
17.	Есөнбулаг сум	"Сүрлэг Алтайн Таван Богд" ХХК	Алтай таван богд супермаркет	Жаргалант	Худалдах
18.	Есөнбулаг сум	"Буман Хүслэн" ХХК	Мөнх цаст Дүнжингарав дэлгүүр	Баянхайрхан баг	Худалдах
19.	Есөнбулаг сум	"Сутайн их өгөөж" ХХК	Бүрэн супермаркет	Оргил баг	Худалдах
20.	Есөнбулаг сум	"Мөст дэвэг" ХХК	Соосойн булаг хүнсний дэлгүүр	Харзат баг	Худалдах

21.	Есөнбулаг сум	"Баянхайрхан-Алтай" ХХК	Баянхайрхан хүнсний дэлгүүр	Түмэн баг	Худалдах
22.	Эрдэнэ сум	"Удмын түшиг" ХХК	Удмын түшиг хүнсний дэлгүүр	Сумын төв	Худалдах
23.	Эрдэнэ сум	"Түчи ма төртегөлдөр" ХХК	Наранбулаг хүнсний дэлгүүр	Сумын төв	Худалдах
24.	Эрдэнэ сум	"Утга-Уул" ХХК	Эрдэнэ-Уул хүнсний дэлгүүр	Сумын төв	Худалдах

__оОо__